



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.22 № 434

танай _____-ы № _____-т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.МӨНХБАЙГАЛЬ ТАНАА

Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг зөвлөмж, албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг 5 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт ^{д/б}... хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР



023030455

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2021/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө	13
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	14
3.5.3 Авлага	14
3.5.4 Урьдчилгаа	14
3.5.6 Бараа материал	14
3.5.7 Үндсэн хөрөнгө	15
3.5.8 Өр төлбөр	15
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5.10 Орлогын данс	16
3.5.11 Зардлын данс	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	18
3.7 Шилэн дансны мэдээлэл	20
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	21
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	21
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22
6. Албан шаардлага	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.22 № 422
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ
ДАРГАА.МӨНХБАЙГАЛЬ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	656,229.2	1,140,562.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	115,228.7	355,857.2
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	338,715.7	452,916.3
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	196,684.8	326,189.2
36	НӨӨЦИЙН БАРАА	5,600.0	5,600.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,015,435.1	6,484,319.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж	0.0	0.0
37200	Үнэт цаас	0.0	0.0
37300	Урт хугацаат зээл	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,015,435.1	6,484,319.7
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	5,875,633.1	6,344,517.7
39300	Биет бус хөрөнгө	139,802.0	139,802.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,671,664.3	7,624,882.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	68,307.7	75,845.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,307.7	75,845.1
41100	Богино хугацаат үнэт цаас	0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.0	0.0
41300	Өглөг	68,307.7	75,845.1
41400	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,603,356.6	7,549,037.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,603,356.6	7,549,037.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,238,478.4	1,238,478.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	0.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	0.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн	4,789,387.8	5,735,068.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	575,490.5	575,490.5
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	0.0
51600	Нөөцийн сан	0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо	0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,671,664.3	7,624,882.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,290,344.1	3,998,377.5
ТАТВАРЫН ОРЛОГО	138,494.4	293,337.2
Орлогын албан татвар	81,211.1	69,257.4
Хувь хүний орлогын албан татвар	81,211.1	69,257.4
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
Хөрөнгийн албан татвар	2,610.0	92,104.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
Онцгой албан татвар	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	54,673.3	131,975.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,056,250.3	826,751.3
Нийтлэг татварын бус орлого	3,056,250.3	826,751.3
Хөрөнгийн орлого	0.0	0.0
Тусламжийн орлого	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
Зээлийн орлого	0.0	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095,599.4	2,878,289.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,344,173.4	2,865,308.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,344,173.4	2,865,308.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,261,447.6	2,713,154.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,266,957.8	1,419,969.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,468.9	179,507.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,486.6	337,104.0
Хангамж, бараа материалын зардал	101,479.8	106,766.5
Нормативт зардал	131,789.3	136,184.3
Эд хогшил, урсгал засварын зардал	21,248.1	14,638.8
Томилолт, зочны зардал	7,698.8	8,165.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,287.6	31,547.2
Бараа үйлчилгээний бусад зардал	278,030.8	479,271.8
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,725.9	152,153.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,946,170.7	1,133,069.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	135,347.1	187,388.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,810,823.6	945,680.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,294,483.8	3,118,998.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	138,494.4	293,337.2
110	Орлогын албан татвар	81,211.1	69,257.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	81,211.1	69,257.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	2,610.0	92,104.7
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	54,673.3	131,975.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,309.3	22,465.8
1181	Газрын төлбөр	7,983.1	8,757.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	29,380.9	100,752.3
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,120.0	120,871.9
120	Нийтлэг татварын бус орлого	36,120.0	120,871.9
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,119,869.4	2,704,788.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,102,477.5	2,622,224.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,102,477.5	2,622,224.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,993,940.5	2,446,087.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,262,574.6	1,406,318.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,259.1	181,233.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,222.6	404,443.3
2104	Хангамж, бараа материалын зардал	82,121.5	71,728.4
2105	Нормативт зардал	84,974.5	138,230.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,356.7	29,539.1
2107	Томилолт, зочны зардал	7,298.8	8,165.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,758.6	30,518.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,374.1	175,910.5
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,537.1	176,137.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	192,006.3	496,773.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	133,981.9	230,145.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	133,981.9	230,145.5
2200	Дотоод эх үүсвэрээр	133,981.9	230,145.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-133,981.9	-230,145.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-6,000.0	-26,000.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,000.0	26,000.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,024.4	240,628.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,204.3	115,228.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	115,228.7	355,857.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,799,917.5	0.0	3,799,917.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,384.4	0.0	-7,384.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,792,533.0	0.0	3,792,533.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	2,810,823.6	0.0	2,810,823.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,603,356.6	0.0	6,603,356.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,603,356.6	0.0	6,603,356.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,603,356.6	0.0	6,603,356.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	945,680.7	0.0	945,680.7
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,549,037.3	0.0	7,549,037.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,713,974.10	2,509,362.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,472,544.20	2,325,984.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,443,945.80	2,297,402.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,366,954.80	1,315,662.39
210101	Үндсэн цалин	869,017.80	815,396.33
210102	Нэмэгдэл	348,833.30	384,741.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,820.00	3,933.00
210104	Урамшуулал	101,956.60	98,414.39
210105	Гэрээт ажлын хөлс	38,327.10	13,176.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,115.60	168,902.20
210201	Тэтгэврийн даатгал	128,688.40	120,968.12
210202	Тэтгэмжийн даатгал	13,356.70	12,052.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,685.50	9,567.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,671.40	2,392.16
210205	Эрүүл мэндийн даатгал	26,713.60	23,921.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	440,267.90	404,443.33
210301	Гэрэл, цахилгаан	22,651.50	24,743.52
210302	Түлш, халаалт	412,632.40	376,491.51
210303	Цэвэр, бохир ус	4,984.00	3,208.30
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	65,517.10	65,406.52
210401	Бичиг хэрэг	5,048.40	5,087.70
210402	Тээвэр, шатахуун	44,125.50	44,199.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,413.60	6,426.60
210404	Ном, хэвлэл	628.20	407.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	697.70	697.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,603.70	8,587.40
2105	Нормативт зардал	145,342.40	102,541.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,956.50	35,956.41
210502	Хоол, хүнс	96,901.00	54,100.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,484.90	12,484.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,255.70	46,200.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,500.00	27,500.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	18,755.70	18,700.79
2107	Томилолт, зочны зардал	8,628.80	8,165.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	8,628.80	8,165.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,597.40	37,220.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,568.50	29,557.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,319.40	2,290.00
210803	Даатгалын үйлчилгээ	825.20	821.70
210804	Тээврийн хэрэгслийн татвар	304.50	297.60

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86.00	54.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.00	4,200.00
210807	Газрын төлбөр	293.80	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,266.10	148,860.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,117.80	139,737.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,148.30	9,123.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,598.40	28,581.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,598.40	28,581.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,001.80	23,001.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,596.60	5,580.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,413.40	157,378.08
223001	Бусад хөрөнгө	157,413.40	157,378.08
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	84,016.50	26,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	84,016.50	26,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,713,974.10	2,655,895.37
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,407,249.60	1,313,527.54
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,407,249.60	1,313,527.54
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,194,764.80	1,229,972.75
320001	Орон нутгийн төсвөөс	1,037,351.40	1,072,559.35
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	157,413.40	157,413.40
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,912.40	26,089.65
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,912.40	26,089.65
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	87,047.30	86,305.43
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,753.70	86,005.43
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300.00	300.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,993.60	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	49,208.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	195,210.96

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,754.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,754.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,921.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,175.87
210101	Үндсэн цалин	90,175.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,331.53
210201	Тэтгэврийн даатгал	12,331.53
2104	Хангамж, бараа материалын зардал	6,321.90
210401	Бичиг хэрэг	296.00
210402	Тээвэр, шатахуун	1,360.00
210404	Ном, хэвлэл	3,918.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	747.70
2105	Нормативт зардал	35,638.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,638.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,122.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,122.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,109.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,221.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,731.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,490.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,833.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,610.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,610.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,223.15
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	1,088.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	24,135.15
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	278,954.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	278,954.69
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,304.41
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	189,850.29
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	4,200.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,200.45

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Норовлин сумын Засаг дарга А.Мөнхбайгаль танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 64 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төсвийн тухай хуульд "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хяналт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,073.2 сая төгрөгийн 1 хувь буюу 30.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд тайлант онд нийт зардал буурсан тул шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзэж 20.1 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 115.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 355.9 сая төгрөг болж, 240.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	115.2	347.9	232.7	98%
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	8.0	8.0	2%
Бусад төсөл, нөөцийн харилцах	-	-	-	0%
Дүн	115.2	355.9	240.7	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн 355.9 сая төгрөгийн үлдэгдэлд орон нутгийн тусгай сангийн төрийн сан дахь харилцах дансанд 194.1 сая төгрөг, төсөвт байгууллагын харилцах дансанд 5.4 сая төгрөг, төрийн сан дахь ерөнхий орлогын дансанд 156.4 сая төгрөг байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой нийт 21.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- ИТХ-д анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 0.3 сая төгрөгийн томилолт олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон

- Хүүхдийн цэцэрлэг: Мөнгөн хөрөнгө зарцуулахдаа анхан шатны баримт болох и баримтыг үндэслээгүй 21.6 сая төгрөгийг зарцуулсанд зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөж хүргүүлсэн;

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 338.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 452.9 сая төгрөг болж, 114.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	7.5	16.1	8.6	3.55%
Дансны авлага /ТӨҮГ/	0	0	-	0.00%
Төлбөртэй үйлчилгээний авлага	0	198.7	198.7	43.87%
Татаас, санхүүжилтийн авлага	0	0	-	0.00%
Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	0	2.8	2.8	0.00%
Бусад авлага	63.9	28.4	(35.5)	6.27%
Зээлийн авлага	267.3	206.9	(60.4)	45.68%
Дүн	338.7	452.9	114.2	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд авлага 452.9 сая төгрөгийн үлэгдэлд сум хөгжүүлэх сан болон, жижиг дунд бизнесийг дэмжих сангийн зээлийн авлагын үлдэгдэл 206.9 сая төгрөг буюу 45.7 хувь, төлбөртэй үйлчилгээний авлага 198.7 сая төгрөг буюу 43.9 хувь, бусад авлага 28.4 сая төгрөг буюу 6.3 хувь, ажиллагчидтай холбоотой авлага 16.1 сая төгрөг буюу 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь Эрүүл мэндийн төвд ЭМДС-аас олгох ковид-19 цар тахлын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой үүссэн төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- ИТХ: Нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн 1.1 сая төгрөгийн үлдэгдлийг авлагаар тусгаагүй зардалд хаасан алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн;

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 196.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 326.2 сая төгрөг болж, 129.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	18.8	18.8	-
Эм боох материал	19.0	103.4	84.40
Бичиг хэргийн материал	8.5	8.5	-

Аж ахуйн материал	19.5	17.4	(2.10)
Сэлбэг хэрэгсэл	-	0	-
Түлш, шатах тослох материал	0.3	0.4	0.10
Барилгын засварын материал	2.5	3.6	1.10
Хүнсний материал	4.3	5.2	0.90
Бусад хангамжийн материал	94.9	139.7	44.80
Мал амьтад	28.9	29.2	0.30
Дүн	196.7	326.2	129.5

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 456.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 69.1 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 396.1 сая төгрөгийн бараа материал зарцуулжээ. Тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан нь эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн материалын нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой 113.8 сая төгрөгийн зөрчил илэрч 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Хүүхдийн цэцэрлэгт жилийн эцэст 3.0 сая төгрөгийн бараа материал, ЭМТ-д эм, боох материалын 102.6 сая төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодоогүй, 8.2 сая төгрөгийн орлогыг анхан шатны баримтын дагуу бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,771.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,494.7 сая төгрөг болж, 722.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	5,475.9	6,005.8	529.9
Тээврийн хэрэгсэл	331.4	235.4	-96.0
Машин тоног төхөөрөмж	476.8	656.3	179.5
Тавилга эд хогшил	218.4	243.3	24.9
Зам, гүүрийн байгууламж	0	0	0.0
Номын фонд	20.5	22.5	2.0
Бусад үндсэн хөрөнгө	107.5	190.0	82.5
Программ хангамж	1.6	1.6	0.0
Бусад биет бус хөрөнгө	139.8	139.8	0.0
ДҮН	6,771.9	7,494.7	722.8

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 72.8 сая төгрөг, улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 746.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 96.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас хассан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 68.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 75.8 сая төгрөг болж, 7.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	12.0	4.8	(7.20)	6%
Бараа үйлчилгээний зардлын өглөг	8.3	65.9	57.60	87%
Байгууллагад төлөх өглөг	48.0	4.7	(43.30)	6%
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	0.4	0.40	1%
Богино хугацаат өр төлбөр нийт дүн	68.3	75.8	7.5	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 75.8 сая төгрөгийн үлдэгдэлд ЭМТ-ийн 68.8 сая төгрөг, ЕБС-ийн 4.4 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 1.8 сая төгрөг, ЗДТГ-ын 0.4 сая төгрөг, Соёлын төвийн 0.3 сая төгрөгийн өглөг эзэлж байна. Материаллаг өөрчлөлт гарсан нь бараа үйлчилгээний зардлын өглөг өссөн байна. Энэ нь ЭМТ-ийн ковид-19 цар тахлын эмчилгээний зардлын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын өр үүссэн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,603.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,549.0 сая төгрөг болж 945.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,238.4	1,238.4	0.0	16.4%
Хуримтлагдсан үр дүн	4,789.4	5,735.1	945.7	76.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	575.5	575.5	0.0	7.6%
Дүн	6,603.3	7,549.0	945.7	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,549.0 сая төгрөг болж 945.7 сая төгрөгөөр өсөхөд тайлант оны үр дүн нөлөөлжээ.

3.5.10 Орлогын данс

Үйл ажиллагааны орлого өмнөх онд 5,290.3 сая төгрөг, тайлант онд 3,998.4 сая төгрөг болж 1,291.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 8. Орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
ТАТВАРЫН ОРЛОГО	138.5	293.3	154.8	7.3%
Орлогын албан татвар	81.2	69.2	(12.0)	
Хөрөнгийн албан татвар	2.6	92.1	89.5	
Бусад татвар, төлбөр хураамж	54.7	132.0	77.3	
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,056.2	826.8	(2,229.4)	20.7%
Торгуулийн орлого	9.5	22.5	13.00	
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,045.2	792.2	(2,253.0)	
Бусад орлого	1.5	12.1	10.60	
Борлуулалтын орлого /ТӨҮГ/	-	-	-	
Хандив тусламж /дотоод/	-	-	-	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095.6	2,878.3	782.7	72.0%
Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих	1,311.3	1,407.2	95.9	
Нэмэлт санхүүжилтийн орлого	81.5	452.5	371.0	
Орон нутгийн төсвөөс санхүүжих	678.4	992.5	314.1	

Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24.4	26.1	1.7	
Үйл ажиллагааны орлогын дүн	5,290.3	3,998.4	(1,291.9)	100.0%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үйл ажиллагааны орлого 3,998.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,291.9 сая төгрөгөөр буурахад үнэ төлбөргүй хүлээж авсан орлого нөлөөлжээ.

Тайлант онд татварын орлого 154.8 сая төгрөг буюу 111.7 хувь, тусламж санхүүжилтийн орлого 37.3 хувиар өссөн байна. Эдгээр орлогууд өсөхөд материаллаг нөлөөлсөн нь тайлант онд малд албан татвар ногдуулж эхэлсэн, нэмэлт санхүүжилтийн дансанд ковид-19 цар тахлын эмчилгээний зардал орж ирсэн зэрэг шинэ төрлийн орлого нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар орлоготой холбоотой нийт 8.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагч: Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг сумын ИТХ-ын тогтоолоор баталснаас ЕБС-д 2.0 сая төгрөгөөр дутуу, Хүүхдийн цэцэрлэгт 2.0 сая төгрөгөөр илүү, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.0 сая төгрөг шилжүүлж, санхүүжилт илүү олгосон зэрэг нийт 7.0 сая төгрөгийн зөрчил давтан илэрч өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагч: Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд ЖДҮДС-д орлогыг 0.5 сая төгрөг, СХС-д зарлагыг 0.5 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт зардлыг 0.5 сая төгрөг, нийт 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

3.5.11 Зардлын данс

Тайлант оны нийт зардал 2,865.3 төгрөг болж өмнөх оноос 521.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9. Зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,261.5	2,713.2	451.7	95%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,267.0	1,420.0	153.0	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158.5	179.5	21.0	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269.5	337.1	67.6	
Хангамж, бараа материалын зардал	101.5	106.8	5.3	
Нормативт зардал	131.8	136.2	4.4	
Эд хогшил, урсгал засварын зардал	21.2	14.6	(6.6)	
Томилолт, зочны зардал	7.7	8.2	0.5	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26.30	31.5	5.2	
Бараа үйлчилгээний бусад зардал	278.0	479.3	201.3	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82.7	152.1	69.4	5%
Бусад урсгал шилжүүлэг	17.2	57.3	40.1	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1.6	1.1	(0.5)	

Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	63.9	93.7	29.8	
Дүн	2,344.2	2,865.3	521.1	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, төвлөрүүлэх шилжүүлэг зэрэг зардлууд өсөж, урсгал засварын зардал буурсан байна.

Нийт зардал өсөхөд “ковид-19” цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдалтай холбоотой цалин хөлс, шимтгэл, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, эм эмнэлгийн хэрэгслийн зардал, шинэ цэцэрлэгийн барилга ашиглалтад орсонтой холбоотой байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой нийт 106.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 7.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 99.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Төсвийг зориулалт бусаар зарцуулж ЗДТГ-т удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халсны ажилгүй байх хугацааны цалинг анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу 2.9 сая төгрөгийг төсвөөс олгосон, ЕБС-д багаж техник хэрэгслийн зардлаас цалингийн зардалд гүйлгэн 4.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зэрэг нийт 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин ЗДТГ-т 15.3 сая төгрөг, ЕБС-д 1.9 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 1.3 сая төгрөг, Соёлын төв 7.7 сая төгрөгийг тус тус хэмнээгүй зэрэг 26.2 сая төгрөгийн зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.
- Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин ЗДТГ-т 1.2 сая төгрөг, ЕБС-д 5.1 сая төгрөг, Соёлын төвд 25.9 сая төгрөг, нийт 32.2 сая төгрөг зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.
- Анхан шатны баримтыг үндэслэн Нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс ЭМТ-д ажилтнуудад олгосон цалингийн зардлыг Нийгмийн даатгалын байгууллагад 40.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Норовлин сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 11 дүгээр тогтоолд зааснаар Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 136.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 327.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 240.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	20.0	22.5	2.5	112.5%
Хөрөнгийн орлого	43.0	45.2	2.2	105.1%
Хөрөнгө борлуулсны орлого	-	1.3	1.3	0.0%

Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.3	0.3	-	100.0%
Бууны албан татвар	2.8	2.8	-	100.0%
Малд ногдуулах албан татвар	-	89.3	89.3	0.0%
Улсын тэмдэгтийн хураамж	3.0	4.7	1.7	156.7%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.0	2.5	1.5	250.0%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11.0	15.3	4.3	139.1%
Газрын төлбөр	4.0	8.7	4.7	217.5%
Ойн нөөц ашигласны төлбөр	25.0	43.4	18.4	173.6%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	16.7	57.3	40.6	343.1%
Торгуулийн орлого	8.0	22.5	14.5	281.3%
Бусад орлого	1.5	12.1	10.6	806.7%
Нийт дүн	136.3	327.9	191.6	240.6%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг орлогын нэр төрлөөрөө давуулан биелүүлсэн байна. Материаллаг өсөл гарсан нь:

- Малын тоо, толгойн албан татварыг тайлант онд төлөвлөөгүй ба 2021 оноос хэрэгжиж эхэлсэн;
- Байгалын нөөц ашигласны төлбөр давж биелсэн нь шонхор агнах зөвшөөрлийн тоо төлөвлөснөөс нэмэгдсэн;
- Торгуулийн орлого давж биелсэн нь замын цагдаагийн торгуулийн орлого орон нутагтаа ордог болсонтой холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд сумын төсвийн орох орлогыг 122.4 сая төгрөгөөр, аймгийн төсөвт орох орлогыг 140.0 сая төгрөг, нийт 262.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сумын төсөвт орох орлогыг 13.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 136.3 сая төгрөг, аймгийн төсөвт орох орлогыг 0.3 сая төгрөгөөр бууруулж нийт 140.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2,714.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,472.6 сая төгрөгийг урсгал зардалд, 157.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 84.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,407.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,037.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 157.4 сая төгрөгийг ОНХС-аас, 24.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс, 87.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлж, аймгаас 835.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлийг авч үзвэл:

- Тусгай зориулалтын шилжүүлгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, 1,313.5 сая төгрөгийг зарцуулж 93.7 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн.
- Орон нутгийн төсвөөс санхүүжих 1,037.3 сая төгрөгийн санхүүжилт авч 987.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 50.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт эргэн төвлөрүүлсэн.

- ОНХС-аас нийт 9 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан 157.4 сая төгрөгийн төсвийг бүрэн зарцуулж, малын тоо толгойн албан татварын 85.2 сая төгрөгийн орлого орж, 107.9 сая төгрөгийн үлдэлтэй байна.
- Аймгийн төвөөс олгох 835.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч зарцуулсан байна.
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 86.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 22.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,509.4 сая төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 146.5 сая төгрөг, эргэж төлөгдөх зээл 58.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Бараа үйлчилгээний зардлын хэмнэлт гарахад материаллаг өөрчлөлт орсон нь Соёлын төвийн барилга ашиглалтад ороогүйгээс халаалтын зардал 36.1 сая төгрөг, ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас цэцэрлэгийн хоол, хүнсний зардал 42.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Эргэж төлөгдөх зээлд 87.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч 26.1 сая төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01/2191 албан бичгээр сум хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг түр зогсоосон шийдвэр гарсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс хэмнэгдсэн нийт 143.7 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 88.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 189.8 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 0.8 сая төгрөг, нийт 278.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 220.9 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 28.6 сая төгрөг зарцуулж, 25.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 4.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Норовлин сумын ТТЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар шилэн данстай холбоотой нийт 317.7 сая төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- ЭМТ-д: таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9,184.6 мянган төгрөгийн 1 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 63,988.5 мянган төгрөгийн 16 мөнгөн гүйлгээ, зарлагын 29,381.2 мянган төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 2,771.2 мянган төгрөгийн 5 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг бүрэн

хэрэгжүүлээгүй зөрчил давтагдан гарсан зэрэг 105.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

- Соёлын төвд: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 164.9 сая төгрөгийн 11 орлогын гүйлгээ, 47.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 212.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 4 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн ба биелэлтийг заасан хугацаанд ирүүлсэн боловч төсвийн гүйцэтгэлтэй холбоотой зөрчил давтан гарч аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитаар нийт 8.5 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Мөнгөн гүйлгээний тайланд нэгтгэсэн тайланд ЖДҮДС-д орлогыг 0.5 сая төгрөгөөр дутуу, СХС-д зарлагыг 0.5 сая төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэгт зардлыг 0.5 сая төгрөг, нийт 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг сумын ИТХ-ын тогтоолоор баталснаас ЕБС-д 2.0 сая төгрөгөөр дутуу, Хүүхдийн цэцэрлэгт 2.0 сая төгрөгөөр илүү, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.0 сая төгрөг шилжүүлж, санхүүжилт илүү олгосон зэрэг нийт 7.0 сая төгрөгийн зөрчил давтан илэрч өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн зөвлөмж:

Зөвлөмж хүргүүлээгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 6, ОНӨААН 1, тусгай сан 3, төрийн сан 1, нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдаж, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 561.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.1 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 530.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага хүргүүлж, 7.7 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн. /Хавсралт-1/

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт-1

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022.03.25	Аудитын нэр: Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код: ХЭА-2022/13/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
1	Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг сумын ИТХ-ын тогтоолоор баталснаас ЕБС-д 2.0 сая төгрөгөөр дутуу, Хүүхдийн цэцэрлэгт 2.0 сая төгрөгөөр илүү, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.0 сая төгрөг шилжүүлж, санхүүжилт илүү олгосон зэрэг нийт 7.0 сая төгрөгийн зөрчил давтан илэрч өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй	7.0	Албан шаардлага хүргүүлсэн.	Засаг дарга, Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	А.Мөнхбайгаль, Л.Энхдорж
2	Мөнгөн гүйлгээний тайланд нэгтгэсэн тайланд ЖДҮДС-д орлогыг 0.5 сая төгрөгөөр дутуу, СХС-д зарлагыг 0.5 сая төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэгт зардлыг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.	1.5	Санхүүгийн тайланд залруулга хийсэн.	Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	Л.Энхдорж
ТТЗ-ийн дүн		8.5			
Иргэдийн төлөөлөгчдийн хурал					
1	Нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг авлагаар тусгаагүй зардалд хаасан	1.1	Санхүүгийн тайланд залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Л.Энхдорж
2	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 276.0 мянган төгрөгийн томилолт олгосон	0.3	Төлбөрийн акт тогтоосон	ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	Б.Тунгалагмөрөн, Л.Энхдорж
дүн		1.4			
Засаг даргын тамгын газар					
1	Нярав Д.Отгонзаяаг удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халсны ажилгүй байх хугацааны цалинг анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу 2.9 сая төгрөгийг төсвөөс олгож, Захиргааны ерөнхий хуулийн 103.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.	2.9	Төлбөрийн акт тогтоосон	ЗДТГ-ын дарга, Нягтлан бодогч	Х.Баасансүрэн, Л.Энхдорж

2	Норовлин сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 13-ны өдрийн А/136 дугаар захирамжаар Засаг даргын нөөц сангаас албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 1.2 сая төгрөг олгосон.	1.2	Албан шаардлага хүргүүлсэн.	ЗДТГ-ын дарга, Нягтлан бодогч	Х.Баасансүрэн, Л.Энхдорж
3	Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 9.5 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй, ЗДТГ-ын албан хаагчдад биеийн тамирын хувцас хийлгэхэд төсвөөс 5.8 сая төгрөгийг зарцуулж, МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй.	15.3	Албан шаардлага хүргүүлсэн.	ЗДТГ-ын дарга, Нягтлан бодогч	Х.Баасансүрэн, Л.Энхдорж
ДҮН		19.4			
Ерөнхий боловсролын сургууль					
1	МУ-ын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 1.9 сая төгрөгийг зарцуулсан	1.9	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	ЕБС-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Наранбаяр, М.Мөнхгэрэл
2	Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчиж 5.1 сая төгрөгийг зарцуулсан.	5.1	Албан шаардлага өгсөн	ЕБС-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Наранбаяр, М.Мөнхгэрэл
3	Багаж техник хэрэгслийн зардлаас цалингийн зардалд батлагдсан төсвийг гүйлгэж 4.4 сая төгрөгийн өр үүсгэж үр дүнгийн урамшуулал олгосон.	4.4	Төлбөрийн акт тогтоосон	ЕБС-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Наранбаяр, М.Мөнхгэрэл
ДҮН		11.4			
Хүүхдийн цэцэрлэг					
1	Жилийн эцэст 3,050.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй.	3.0	Албан шаардлага хүргүүлсэн.	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Ө.Алтанзул, М.Мөнхгэрэл
2	Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 520.0 төгрөгийн шагнал урамшуулал, 560.0 төгрөгийн сургалт, 182.0 мянган төгрөгийн албан томилолт нийт 1,262.0 мянган төгрөгийн зардлуудыг тус тус зарцуулсан.	1.30	Албан шаардлага хүргүүлсэн.	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Ө.Алтанзул, М.Мөнхгэрэл
3	Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 21,637.1 мянган төгрөгөөр дутуу	21.6	Зөвлөмж өгсөн	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Ө.Алтанзул, М.Мөнхгэрэл
ДҮН		25.9			
Соёлын төв					
1	Бусад бараа үйлчилгээний зардлаас 25.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй;	25.9	Албан шаардлага хүргүүлсэн.	Соёлын төвийн дарга, нягтлан бодогч	Г.Мөнхгэрэл, У.Золбоо

2	Зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлыг тэвчиж, батлагдсан зардлын дүнд 7.7 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй; зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлэв	7.7	Албан шаардлага хүргүүлсэн.	Соёлын төвийн дарга, нягтлан бодогч	Г.Мөнхгэрэл, У.Золбоо
3	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 164.9 сая төгрөгийн 11 орлогын гүйлгээ, 47.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;	212.3	Албан шаардлага хүргүүлсэн.	Соёлын төвийн дарга, нягтлан бодогч	Г.Мөнхгэрэл, У.Золбоо
ДҮН		245.9			
Эрүүл мэндийн төв					
1	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9,184.6 мянган төгрөгийн 1 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 63,988.5 мянган төгрөгийн 16 мөнгөн гүйлгээ, зарлагын 29,381.2 мянган төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 2,771.2 мянган төгрөгийн 5 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил давтагдан гарсан.	105.4	Албан шаардлага хүргүүлсэн.	Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч	Г.Ариунзул, Х.Оюунгэрэл
2	Санхүүгийн тайлан бэлтгэн гаргахдаа эм, боох материал дансны 102,583.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодоогүй	102.6	Албан шаардлага хүргүүлсэн.	Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч	Г.Ариунзул, Х.Оюунгэрэл
3	Нягтлан бодох бүртгэлд бараа материалын 8,205.6 мянган төгрөгийн орлогыг анхан шатны баримтын дагуу бүртгээгүй	8.2	Албан шаардлага хүргүүлсэн.	Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч	Г.Ариунзул, Х.Оюунгэрэл
4	Ажилтнуудад олгосон цалинг Нийгмийн даатгалын байгууллагад 31,749.2 мянган төгрөгөөр илүү, 9,051.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	40.7	Албан шаардлага хүргүүлсэн.	Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч	Г.Ариунзул, Х.Оюунгэрэл
ДҮН		256.9			
СХС /Түүвэрт хамрагдсан/					
	Аудитаар зөрчил илрээгүй	-			
ЖДБДС /Түүвэрт хамрагдсан/					
	Аудитаар зөрчил илрээгүй	-			
ОНХС /Түүвэрт хамрагдсан/					
	Аудитаар зөрчил илрээгүй	-			
Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн		561.0			
НИЙТ ДҮН		569.5			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 22

Дугаар 246/А2370 449
ХТ-А 2022/13/НА-СТАТЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Норовлин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг сумын ИТХ-ын тогтоолоор баталснаас ЕБС-д 2.0 сая төгрөгөөр дутуу, Хүүхдийн цэцэрлэгт 2.0 сая төгрөгөөр илүү, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.0 сая төгрөгөөр илүү олгосон зэрэг нийт 7.0 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.5-д "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг илүү, дутуу олгох зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Норовлин сумын Засаг дарга А.Мөнхбайгаль, ерөнхий нягтлан бодогч Л.Энхдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА

